


Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг байгууллагуудын 2023 оны 1 дүгээр улирлын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн товч танилцуулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаардаг 199 байгууллага нь 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар шилэн дансны цахим системд нийт 7697 мэдээлэл байршуулах ёстойгоос 92,1% буюу 7093 мэдээллийг хуулийн хугацаанд, 2,1% буюу 160 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 5,8% буюу 444 мэдээлэл огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 92.1 хувьтай гарлаа.




Мэдээлэл байршуулалтыг өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулбал:




Мэдээлэл байршуулалтыг байгууллагын төрлөөр нь ангилан харуулбал:

Төсвийн 1 байгууллага 1 дүгээр улирлын байдлаар 39 мэдээлэл байршуулах ёстой ба 165 байгууллага нийтдээ 6435 мэдээлэл байршуулах ёстойгоос 5980 мэдээллийг хуулийн хугацаанд, 108 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 51 байгууллага 347 мэдээллийг огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 92,9 хувьтай гарлаа.




Диаграмм 3. Шилэн дансанд мэдээлэл байршуулалт

Төрийн сан 1 дүгээр улирлын байдлаар 1 байгууллага 45 мэдээлэл, 20 төрийн сан нийтдээ 900 мэдээлэл байршуулахаас 788 мэдээллийг хуулийн хугацаанд, 29 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бол 83 мэдээллийг огт байршуулаагүй ба мэдээллийг хуулийн хугацаанд байршуулалт 87,5 хувьтай байна.



Диаграмм 4 Төрийн сангуудын мэдээлэл байршуулалт

Орон нутгийн өмчит 15 байгууллага нь нийт 362 мэдээлэл байршуулахаас 325 мэдээллийг хуулийн хугацаанд, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба 14 мэдээлэл огт байршуулаагүй байна. Эндээс хуулийн хугацаанд мэдээлэл байршуулалт 89,8 хувьтай гарлаа.



Диаграмм 5. Орон нутгийн өмчит байгууллагуудын мэдээлэл байршуулал

Зургаа. Шалгалтын дүгнэлт

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагддаг 201 байгууллагын 2023 оны шилэн дансны мэдээ тайланг хуулийн хугацаанд байршуулсан байдал, шилэн дансны системд улирлын мэдээг илгээсэн, шилэн дансны шинэ цахим системд бүртгүүлсэн зэрэгт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Энэ удаагийн шалгалтаар шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулалт 92,1 хувь, шилэн дансны шинэ цахим системийн бүртгэлжүүлэлт 99 хувьтай байна. Шинэ нэгдсэн цахим системд бүртгүүлээгүй Нарийнтээл сумын Соёлын төв, Өв.Эко мийт ОНӨҮГазруудыг бүртгүүлэх шаардлагатай байна.

Төсвийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансанд байршуулах мэдээллээ бүрэн сонгож өгөөгүйн улмаас мэдээлэл огт байршуулаагүй харагдаж байгаа тул байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэл болон оруулах мэдээллээ бүрэн гүйцэд сонгож оруулах хэрэгтэй.

Шилэн данс хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээлэл байршуулах үйл ажиллагаанд гарч байгаа зөрчлүүд нь мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн хариуцлагагүй байдал, мөн мэдээлэл байршуулалтад тавих удирдлагын болон дотоод хяналтын тавих хяналтууд байхгүйгээс мэдээлэл байршуулалт муу, хуулийн хугацаанд мэдээллээ бүрэн гүйцэд

байршуулахгүй байгаа тул цаашид төсвийн шууд захирагч нар шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, үүнд дотоод хяналтын нэгжийг татан оролцуулах, мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан хаагчийн ажлын хариуцлагыг сайжруулах, ажил дүгнэх үзүүлэлтэд харгалздаг болох, мэдээлэл байршуулж байгаа албан хаагчид шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулахдаа мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн гүйцэд, үнэн зөв байршуулах, мэдээлэл хоорондын уялдааг хангаж ажиллах шаардлагатай байна.

Долоо. Байгууллагуудын цаашид анхаарах асуудлууд

1. Байгууллагын удирдлага болон дотоод хяналтын нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулж байгаа мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв хуулийн хугацаанд байршуулж байгаа эсэхэд улиралд нэгээс доошгүй удаа хяналт тавих;

2. Шинэ нэгдсэн цахим системд бүртгэлгүй байгаа Нарийнтээл сум Соёлын төв, Өв.Эко мийт ОНӨҮГазрыг бүртгүүлэх, мэдээллээ бүрэн гүйцэд байршуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах;

3. Байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэл болон заавал оруулах мэдээллээ бүрэн гүйцэд сонгож оруулах;

4. Шилэн дансны шинэ цахим системийн тухай сургалт, сурталчилгааг аймгийн хэмжээнд зохион байгуулах арга хэмжээг авах;

5. Өгсөн үүрэг даалгавар болон зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах;